

# “БЗӨБЦТС” ТӨХК-ИАС 2026 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ТАЙЛАН

## Бүх нийтийн цэвэрлэгээнд нэгдлээ

Сар шинийн баярын өмнөх бүх нийтийн цэвэрлэгээнд төв компани, 5 салбарын нийт ажилтнууд хамрагдаж байгууллага тус бүрийн эзэмшлийн 50 м хүртэлх зам талбайн мөн хуваарьт газрын цэвэрлэгээг зохион байгуулж, үүсмэл хогийн цэгүүдийг ачиж зайлуулав.



Мөн хуваарьт газрын нийтийн эзэмшлийн зам талбайн цас цэвэрлэгээг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.



### Хөдөлгөөн эрүүл мэнд

Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг Дорноговь ЦТСС-ын ажилтнууд өдөр бүр 5-10 минутын өглөөний дасгал хийж хэвшсэн.

ХАБЭЗ-н эвчлэл  
2025.03.19

**ЗАРЛАЛ**  
ЭРЧИМ ХУЧНИЙ САЛГАРЫН ХӨДӨЛГӨӨРИЙН АСУУЛГҮЙ  
БАЙДАЛ ЭРҮҮЛ АЖИЛ САРЧАН АЛБЫГ УТГАЖ АЖИЛ ЗОХИОН  
БАЙГУУЛЖ БАЙНА.

**Ажил 1**  
Ажлын байрны дасгал хөдөлгөөн

Ажлын өдөр бүр 08.05-08.15 ЦАГ ХҮРТЭЛ ӨГЛӨӨНИЙ ДАСГАЛ  
ХӨДӨЛГӨӨНИЙ ЭХЭЛЖ БАЙНА ТА БҮХЭН ИДЭВХТЭЙ ОРОЛЦОНО УУ!  
[@](mailto:ИРЦ.БҮРТГЭНЭ.УРАМИШУУЛАЛТАЙ.ШҮҮ)



Дорноговь ЦТСС-ын төвийн ажилтнуудын дунд Energy мини лиг спортын 3 төрөлт тэмцээнийг 3-р сарын 3-ны өдрөөс эхлэн явуулж байна.





Дундговь ЦТСС нь жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг салбарын спортын 5 төрөлт тэмцээн /Волейбол, 3х3 сагсан бөмбөг, и спорт, корнхол/ төрлүүдээр 2026 оны 01 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан.



### Сургалт, хөгжүүлэлтийн чиглэлээр

Тус компани нь жил бүр ажилтнуудын хэрэгцээ шаардлагад тулгуурлан ээлжит сургалтын зохион байгуулдаг бөгөөд 2026 оны ээлжит сургалтыг 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс 02 дугаар сарын 03-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн”, мэргэжлийн сургалт, Хууль эрх зүйн мэдлэг олгох, бусад сэдвээр 100 цагийн сургалтад компанийн нийт 540 гаруй ажилтныг хамрууллаа.

2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр			
6	Төхийн бодлогын бичиг баримтын ерөнхий агуулга, гол зарчим, техникийн нөхцөл огцомын талаар	Мэргэжлийн ажиллагсад	УБЦТС ТӨХЖ-ийн ИТА нар
7	САС системийн талаар	Цайны цаг	
8	Ухаалаг тоогуурын системийн талаар	Мэргэжлийн ажиллагсад	УБЦТС ТӨХЖ-ийн ИТА нар
9	Газар зүйн мэдээллийн санд суурилсан ArcGIS системийн талаар		
10	СКАДА системийн хөгжүүлэлтийн талаар гэх мэт	2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр	
11	Нэгдсэн сулсэнд дүрэм, Нэгдсэн сулсэнд гарсан аварга устгах болон цахилгааны хуваарилалт байгууламид сэлэн загварт ийх заваруудын эмхэтгэл	Мэргэжлийн ажиллагсад	ШУТХ-ийн дарга Т.Гантөгс
12	Ес зүйн дүрэм, ес зүй дэд, салбар хорооны ажиллах зарчмыг	Нийт ажиллагсад	ЭХНХ-ийн ахлах хуулийн зөвлөх Ес зүйн дэд хорооны дарга Б.Шинэтуяа
Цайны цаг			
13	Хэрэгжж байгаа хуулийн танилцуулга	Нийт ажиллагсад	Шуудын тэмцлийн газрын дарга Б.Эрдэнэбаяр
14	Бие хүмэй сэтгэл зүй		Сэтгэл судлал ба гэр бүл хөгжлийн тоонот төвийн бэлэн
15	Цахилгаан байгууламийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм 12 дугаар бүлэг Албан томилолтоор ажил гүйцэтгэх		ХААХ-ийн ахлах, ХАБЭЗАХ-ын инженер Д.Цэцэгээ

ХА-01.ЖУ-ХАБЭА-03-02

**"БЭӨБЦТС" ТӨХЖ-ИЙН АЖИЛТНУУДАД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
2026 ОНЫ ЭЗЭЛЖИТ СУРГАЛТЫН НЭГДСЭН ХӨТӨЛБӨР**

Зохихон байгуулах хугацаа: 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 01 дүгээр сарын 23-ны өдөр хүртэл

Сургалтын төрөл: Таним болон практик дасгал сургалт

Сургалтын хамрах хүрээ: Төв компани болон Багануур ЦТСС-ын нийт ажилтнууд

№	Сургалтын сэдэв	Хамрагдах нэгж, хэсэг	Сургалт явуулах багш	Сургалт үргэлжлэх хугацаа
2025 оны 01 дүгээр сарын 18-ний өдөр				
1	Цахилгаан байгууламийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм 1 дүгээр бүлэг Ерөнхий зүйл	Нийт ажиллагсад	ХААХ-ийн ахлах, ХАБЭЗАХ-ын инженер Д.Цэцэгээ	08.30-10.00
2	Цахилгаан байгууламийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм 4 дүгээр бүлэг Онцлог нөхцөлтэй цахилгаан байгууламид ажил гүйцэтгэх	Мэргэжлийн ажиллагсад		10.00-11.00
Цайны цаг				
3	Замын хөдөлгөөний шинэчлэгдсэн дүрэм		Дүрмийн бэлэн	13.30-14.30
4	Харигцааны соёл ба хандлага	Нийт ажиллагсад	Насан туршийн суралцагчийн төвийн багш Б.Саруул	14.30-15.30
5	Жендэрийн тухай ойлголт			15.40-16.40



**Нийгмийн хариуцлагын хүрээнд**

Багануур дүүргийн Оюуны эрин цогцолбор сургуулийн хичээлийн 2-р байр Бага ангийн бяцхан дүү нартаа эрчим хүчээ хайрлах, хэмнэх зөв дадал, хэвшилд сургах зорилгоор эрчим хүч хэмнэх энгийн аргуудаар сэдэвчилсэн сургалтыг 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан.



## Бусад

Цагаан сарын баярыг тохиолдуулан Монгол ёс уламжлалаа хүндэтгэн хамт олны нэгдсэн золголтыг зохион байгуулав. Монгол өв уламжлал, ахуй соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх, залуус хойч үедээ таниулах үүднээс ажилтнууд ДӨРВӨН БЭРХ баг болж, Монгол шагайн наадгай, оньсого таавар, сээр цохих уралдааныг зохион байгуулан ажилласан.



Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан хамт олны уур амьсгалыг сайжруулах, бие биедээ талархал илэрхийлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор компанийн эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран “Монита” зохион байгуулж, ажилтнууд идэвхтэй оролцлоо.



### "Монита" удирдамж

- Зорилго
  - Хамт олны уур амьсгалыг сайжруулах
  - Бие биедээ талархах
- Санаачлагч
  - Компанийн эмэгтэйчүүдийн зөвлөл
- Оролцогчид
  - Сайн дурын үндсэн дээр оролцоно Эрэгтэй 55, эмэгтэй 43
  - Бүгд нэрээ жагсаалтад бүртгүүлнэ
- Нэр сугалах журам
  - Бүгдийн нэрийг цаасан дээр бичих
  - Нэг бүрчлэн сугалж, өөрийн нэр таарвал дахин сугалах
  - Хэн хэнийг сугалсан нь нууц байна
  - Нууцыг монита задлах хүртэл хадгална
- Бэлгийн шаардлага
  - Үнийн дүн: 20,000–30,000Т
  - Сэтгэл шингэсэн, тохиромжтой бэлэг сонгоно
  - Доромжилсон, зохисгүй зүйлсээс зайлсхийх
- Хугацаа
  - Нэр сугалах өдөр: 2026.03.04
  - Бэлэг өгөх хугацаа:
    - 2026.03.09 (эрүүл мэндийн)
    - 2026.03.12 (хоол, амттан)
    - 2026.03.18 (оюунлаг)
  - Монита задлах өдөр: 2026.03.18 (таны нэрийг сугалж баярлуулсан хүндээ бэлэг өгөх)
  - Алтан монита (хоёр биенийхээ нэрийг сугалж баярлуулсан монитаг тодруулна)
- Анхаарах зүйл
  - Нууцыг чанд хадгалах
  - Хугацаанаас хоцрохгүй байх
  - Бусдын сонголтыг хүндэтгэх

Багануур ЦТСС-ын жолооч Баярсайханд гадаад улсад эмчлүүлэхэд нь зориулан хандивын аян өрнүүлж компанийн нийт ажилтнуудаас хандивласан 10 сая төгрөгийг гардууллаа.



**СЭТГЭЛИЙН ДЭМ ЭДГЭРЛИЙН ЭХЛЭЛ**

Нэгэн цаг дор түүнэнд гэрэл түгээх үйлсэд хандаж зүтгэж, амьлан хариуцлагаа нэр төртэй биелүүлж явса **Багануур Цахилгаан Түгээх Сүлжээ Салбарын Тээвэр Үйлчилгээний хэсгийн жолооч Батбуян овогтой Баярсайхан** мэвнь эрүүл мэндийн шалтгааны улмаас хүндхэн сорилттой нүүр тулаад байна.

Тэрээр өвдөгний үе бүтэн солиулах (**total knee arthroplasty**) мэс засалд орж, дахин эрүүл саруул алхахан төлөө 2025 оны 2 дугаар сарын 02-ны өдөр БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны эмнэлэгт **100 сая** орчим төгрөгийг эмчилгээ, хагалгаанд орохоор болсон юм.

Энэхүү мэс засал нь түүний цаашдын ажил, амьдралын чанарт шууд нөлөөлөх чухал алхам бөгөөд эдгэрэлтийн замд санхүүгийн дэмжлэг, сэтгэлийн халуун илч нэн шаардлагатай болоод байна. Иймд эрхэм хамт олон **та бид бүгдээрээ нэгхэн өдрийн хоолонд зарцуулах 20,000 төгрөгийг** л хандив болгон өдгөөд хамт олноос нэгэн гишүүний эрүүл мэнд, бүтэн нэг айлд итгэл найдварыг асааж чадах сайн үйлсийг бүтээхэд маш том дэм болж чадна гэж итгэж, хандивын аянд нэгдхийг чин сэтгэлээсээ уриалж байна.

👉 **Нэг сэтгэл - Нэг дэм - Нэг амьдрал**  
Та бүхний халуун сэтгэл, чин үнэн дэмжлэгт талархал илэрхийлье. 🙏



**Сайнзаяа Хннахм Ком**

Хандивт цугларсан нийт 10.0 сая төгрөгийг Б.Баярсайханд хүлээлгэн өглөө. Энэхүү сайн үйлсийн аянд нийт нь нэгнийхээ төлөө гэсэн сэтгэлээр нэгдсэн БЗӨБЦТС ТӨХК-ийн удирдлагууд болон нийт албан хаагчиддаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлснийг та бүхэнд уламжилж байна. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай 🙏❤️

7:31 PM